



СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ


Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Брокер дилер

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ МЭДЭЭ


2020 оны 4-р сар

МХБ-ийн индексүүд

Топ-20 индекс, 16,413 -3.1% (өмнөх сартай харьцуулсан өөрчлөлт)



МХБ-А индекс, 7,677 -2.1%, МХБ-В индекс 7,564 -1.3% (өмнөх сартай харьцуулсан өөрчлөлт)



Олон улсын индексүүд

Индекс	2020.03.31	2020.04.30	Өөрчлөлт, %
DJIA (US)	21,917	24,345	11.0%
S&P 500 (US)	2,584	2,912	12.6%
Nikkei 225 (JP)	18,917	20,193	6.7%
Hang Seng (HK)	23,603	23,613	0.04%
DAX 30 (DE)	9,935	10,861	9.3%
SMI (CH)	9,311	9,629	3.4%

Валютын ханш

Валют	2020.03.31	2020.04.30	Өөрчлөлт, %
USD	2,777.74	2,788.91	0.4%
EUR	3,054.54	3,035.31	-0.6%
JPY	25.62	26.16	2.1%
RUB	35.37	38.37	8.4%
CNY	391.62	395.38	0.9%
KRW	2.28	2.31	1.3%

Арилжааны мэдээ

Хураангуй (өмнөх сартай харьцуулсан өөрчлөлт)

Үзүүлэлт	Дүн	Өөрчлөлт, %
Арилжааны хэмжээ, тэрбум ₮	2.2	-32.5%
Зах зээлийн үнэлгээ, тэрбум ₮	2,427.9	-2.3%
Бүртгэлтэй компани	198	198
Арилжаалагдсан хувьцаа	69	-21
Арилжаалагдсан өдөр	22	0

Хамгийн их өсөлттэй

Хувьцаа	2020.03.31	2020.04.30	Өөрчлөлт, %
BNG	24,000.00	31,000.00	+29%
SUL	62,150.00	79,950.00	+28%
AMT	185.80	225.00	+21%
LEND	29.98	36.00	+20%
SUU	181.60	212.00	+16%

Зах зээлийн мэдээлэл

Хувьцаат компаниудын ХЭХ цахим хэлбэрээр хуралдав

Дэлхий дахинаа шинэ коронавирусын халдвар тархсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас өндөржүүлсэн бэлэн байдал зарлаж, СЗХ, МХБ-ээс хувьцаат компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахимаар хийх зөвлөмж гаргасан тул энэ жил ихэнх компани Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа ЦАХИМ хэлбэрээр хуралдуулав.

ҮЦТХТ-д нээгдсэн дансны мэдээлэл

ҮЦТХТ-д 4-р сард нийт 234,055 данс нээгдсэнээс 183,930 данс шинээр, 50,125 данс холболтоор нээгдсэн ба шинээр нээгдсэн дансдын бүтцийг харвал 234,021 дотоодын иргэн, 6 гадаадын иргэн, 28 дотоодын аж ахуйн нэгжийн данс тус тус нээгдсэн байна. Энэ нь өмнөх сараас 2-3 дахин өссөн үзүүлэлт болсон ба шалтгаан нь Эрдэнэс тавантолгой ХК-наас анх удаа ногдол ашиг тараахаар мэдэгдсэн явдал юм.

ЭТТ 1072 хувьцааны ногдол ашгийн тухай

2012 оны 4-р сарын 11-ний өдрөөр тасалбар болгосон иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдсан Монгол Улсын иргэн бүрт Засгийн газрын 216 тоот тогтоолын дагуу Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 1072 ширхэг хувьцааг эзэмшүүлсэн ба нийт 2,512,768 иргэн тус компанийн хувьцааг эзэмшсэн байна. Гэвч түүнээс хойш 2011-2012 онд эх орны хишиг хувь хүртсэн, оюутны сургалтын төлбөрт суутгуулсан иргэд өнөөдөр хувьцаагүй болсон, мөн эрүүл мэндийн даатгалын шимтгэлд суутгуулсан, 2016 онд “Сайн хувьцаа” хөтөлбөрт хамрагдсан иргэдийн хувьцааны тоо янз бүр байгаа юм. /өөрийн хувьцааны тоо ширхгийн талаар дараах линкээр орж мэдээлэл аваарай <https://www.schcd.mn/?p=6949/>

Эрдэнэс Тавантолгой ХК 2019 онд 60 сая дахь тонн нүүрс олборлож, 1 тэрбум ам.долларын борлуулалттай, 1 их наяд төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, анх удаа хувьцаа эзэмшигч иргэддээ ногдол ашиг хуваарилахаар 2020 оны 2-р сарын 17-ны өдөр шийдвэрлэсэн. Нэгж хувьцаанд 90₮-ийн ногдол ашиг олгох бөгөөд энэ нь ХАОАТатвар хассаны дараа 89₮ болох юм. Нийт хэдэн төгрөгийн ногдол ашиг авахаа өөрийн хувьцааны тоогоор үржүүлэн тооцоорой. Ногдол ашгийг ҮЦТХТ-өөр дамжуулан, иргэдийн баталгаажуулсан банкны данс руу нь 5-р сарын 1-нээс шилжүүлж эхэлнэ гэж Эрдэнэс Тавантолгой ХК-ийн зүгээс 4-р сарын түрш мэдээлсэн. Тиймээс ч энэ сард данс нээлгэх, банкны дансаа холбуулах гэсэн иргэд идэвхжиж, ҮЦК-иуд ихээхэн ачаалалтай ажилласан тул ихэнхдээ утсаар, чатаар холбогдох боломжгүй байсанд хүлцэл өчье.

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн нийт хувьцаа эзэмшигчдээс 850,000 гаруй нь үнэт цаасны дансаа одоо болтол нээлгээгүй, мөн данс нээлгэсэн дийлэнх иргэдийн банкны дансны дугаар зөрүүтэй, эсвэл дансаа холбож баталгаажуулаагүй байгаа аж. 2020 оноос өмнө дансаа нээлгэсэн иргэд тухайн үед банкны дансны мэдээллээ өгч байсан ч ҮЦТХТ-ийн систем шинэчлэгдсэн тул заавал дахин баталгаажуулах шаардлагатай болсон. Мөн, хүүхэд бол аав ээжийн дансаар авч болохгүй, зөвхөн тухайн хүүхдийн нэр дээрх данс байх шаардлагатай гэсэн тул хүүхдийн мөнгө авдаг, эсхүл хадгаламжийн дансыг нь шинээр холбуулах шаардлага үүссэн. Банкны данс хэрхэн холбох мэдээллийг http://www.standardinvestment.mn/mn/home/newsmore_page/18/0/238 линкээр аван, баталгаажуулахыг харилцагчдаасаа хүсье. Дашрамд дурдахад Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Хувьцаа

Хамгийн их бууралттай

Хувьцаа	2020.03.31	2020.04.30	Өөрчлөлт, %
SOH	80.00	41.62	-47%
DAR	5,700.00	4,250.00	-25%
ATI	900.00	700.00	-22%
TTL	6250.00	4,926.00	-21%
SHG	1,199.00	977.00	-18%

Хамгийн их арилжигдсан

Хувьцаа	Тоо ширхэг	Үнийн дүн. сая төг	Эзлэх %
MDR	2,137,879	641.3	28.1%
APU	395,874	213.0	9.3%
SUL	2,234	178.0	7.8%
AARD	115,718	170.9	7.4%
AIC	114,623	101.4	4.4%

Зах зээлийн үнэлгээ хамгийн их өссөн, тэрбум төгрөгөөр

Компани	2020.03.31	Өөрчлөлт	Өөрчлөлт, %
BNG	10.1	2.9	+29.1%
SUL	4.0	1.1	+28.6%
AMT	2.9	0.618	+21.0%
LEND	23.9	4.8	+20.0%
SUU	62.4	10.4	+16.7%

Зах зээлийн үнэлгээ хамгийн их буурсан, сая төгрөгөөр

Компани	2019.03.31	Өөрчлөлт	Өөрчлөлт, %
SOH	1,098.8	527.1	-47.9%
DAR	3,503.2	891.1	-25.4%
ATI	1,362.2	302.7	-22.2%
TTL	329,157.5	69,728.7	-21.1%
SHG	12,194.1	2,257.7	-18.5%

эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 4-р сарын 24-ний өдөр цахим хэлбэрээр нээлтэй хуралдсан.

ТҮЦ машинаас хувьцааны мэдээлэл авдаг боллоо

Төрийн үйлчилгээний цахим систем буюу ТҮЦ машин ашиглан хувьцаа, ногдол ашигтай холбоотой мэдээллээ авах боломжтой болов. Энэхүү шинэ үйлчилгээг ҮЦТХТ-өөс Үндэсний Дата төвтэй хамтран 4-р сарын 22-ноос эхлэн нэвтрүүлээ. ТҮЦ-ээс гадна дараах байдлаар 1072 хувьцаатай эсэх, хувьцааны данстай эсэхээ шалгах боломжтой:

- 158989 дугаарт регистрийн дугаараа латин үсгээр бичиж явуулах
- <https://net.schcd.mn/registration/default.jsp> орж, регистрийн дугаараа кирилл үсгээр бичиж шалгах

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам батламжлагдсан.

МХБ-ийн ТУЗ-ийн 2020 оны 2-р сарын 7-ны өдрийн 2020/06 дугаар тогтоолоор батлагдсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-ыг СЗХ-ны даргын 2020 оны 4-р сарын 10-ны өдрийн 146 тоот тушаалаар батламжилжээ.

Олон улсын жишигт банк, санхүүгийн байгууллагууд активаа багцлан үнэт цаасжуулж, хөрөнгийн зах зээлд худалдан санхүүжилт татах замаар эрсдлээ хуваалцах нь түгээмэл байдаг бөгөөд энэ төрлийн үнэт цаас арилжигдаж эхэлснээр банк, санхүүгийн байгууллагуудад хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүжилтийн шинэ суваг нээгдэх, иргэдэд тогтмол хугацаат хүүгийн орлого бүхий эрсдэл харьцангуй багатай хөрөнгө оруулалтын шинэ бүтээгдэхүүн санал болгох боломж бүрдэх юм байна. Тус журмыг дорх линкээр орж үзнэ үү. http://mse.mn/uploads/images/2088a6~1_1.pdf

Та цахимаар хувьцааны данс нээж, арилжаа хийхийг хүсвэл манай "Цахим данс" системд бүртгүүлээрэй.

Мөн гар утасны аппликэйшн татан авч, онлайн данс нээс нээх, арилжаа хийх, дансаа хянах боломжтой.

"ЦАХИМ ДАНС" СИСТЕМ

<https://dbx.standardinvestment.mn/>

Standard Investment

Available on the App Store

ANDROID APP ON Google play

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ



МӨНГӨ, ЗЭЭЛ

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2020 оны 4-р сарын эцэст 20.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 253.2 (1.3%) тэрбум төгрөгөөр өсөхөд валютын хадгаламж 886.3 (31.0%) тэрбум төгрөгөөр, валютын харилцах 54.4 (2.3%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна. Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2020 оны 4-р сарын эцэст 858.5 тэрбум болж, өмнөх сараас 10.7 (1.2%) тэрбум төгрөгөөр өсөж, өмнөх оны мөн үеэс 74.5 (8.0%) тэрбум төгрөгөөр буурсан байна.


Хүснэгт. Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2019.04	2020.04*
Мөнгө M2	19,909.5	20,162.7
Бага мөнгө M1	3,671.1	3,421.0
Төгрөгийн харилцах	3,030.8	2,833.6
Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө	640.3	587.4
Бараг мөнгө	16,238.4	16,741.7
Төгрөгийн хадгаламж	10,978.6	10,541.3
Валютын хадгаламж	2,863.3	3,749.6
Валютын харилцах	2,396.4	2,450.8
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	933.0	858.5

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 4-р сарын эцэст 17.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 7.6 (0.04%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 514.5 (2.9%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 4-р сарын эцэст 1.3 их наяд төгрөг болж, өмнөх сараас 158.0 (13.7%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 328.0 (33.5%) тэрбум төгрөгөөр өсчээ. Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2020 оны 4-р сарын эцэст 1.9 их наяд төгрөг болж, өмнөх сараас 37.0 (2.0%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 80.0 (4.1%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Зураг 35. Чанаргүй зээл, сарын эцэст, тэрбум төгрөг



УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн нийт хэмжээ 2020 оны 4-р сарын урьдчилсан гүйцэтгэлээр 2.9 их наяд төгрөг, үүнээс нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламж нь 2.7 их наяд төгрөг болж нийт орлогын 93.4 хувийг эзэлж байна. Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 3.3 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 643.5 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.



Эх сурвалж: Монгол улсын үндэсний статистикийн хороо



ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

Төлбөрийн тэнцлийн урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 2020 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 767.0 сая ам. долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 368.9 сая ам. доллараар өсчээ. Урсгал данс 767.0 сая ам. долларын алдагдалтай гарахад үйлчилгээний тэнцэл 281.8 сая ам. доллар, анхдагч орлогын данс 289.6 сая ам. долларын алдагдалтай гарсан нь голлон нөлөөлсөн байна.

Зураг 43. Урсгал данс, сал америк доллароор



ГАДААД ХУДАЛДАА

Монгол Улс 2020 оны эхний 4-р сард нийт 125 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 3.0 тэрбум ам. доллар, үүнээс экспорт 1.4 тэрбум ам. доллар, импорт 1.6 тэрбум ам. долларт хүрлээ. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.3 (30.8%) тэрбум ам. доллар, үүнээс экспорт 1.1 (45.3%) тэрбум ам. доллароор, импорт 179.9 (10.2%) сая ам. доллараар тус тус буурчээ.

Зураг 44. Экспорт, импорт, тэнцэл, сараар, сал америк доллар




Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл 2019 оны 4-р сард 745.8 сая ам. долларын ашигтай гарч байсан бол 2020 оны эхний 4-р сард өмнөх оны мөн үеэс 958.5 сая ам. доллароор буурч, 212.7 сая ам. долларын алдагдалтай байна.



ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 4-р сард улсын хэмжээнд өмнөх сараас 0.6 хувиар буурч, өмнөх оны эцсээс 2.2 хувь, өмнөх оны мөн үеэс 4.7 хувиар өссөн байна.

Зураг 48. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс (өмнөх оны мөн үеэс), хувь, сараар



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 4-р сард өмнөх оны мөн үеэс 4.7 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 7.8 хувь (мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 13.1 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 3.7 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 4.9 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 5.3 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 5.4 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 5.5 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 3.1 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Холбоо барих хаяг

Стандарт инвестмент ҮЦК
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
6-р хороо, Бага тойруу 24,
Монреимпекс ХХК-ийн байр,
2-р давхар, 201 тоот

Утас: 70114433
info@standardinvestment.mn
www.standardinvestment.mn

Шуудангийн хаяг:

Төв шуудан, Шуудангийн хайрцаг 1487
УБ - 15160

Тодруулга болон мэдэгдэл

Энэхүү тойм мэдээ нь ямар нэгэн үнэт цаасыг худалдан авах, худалдах санал биш юм. Энд дурдсан үнэ ханшийн мэдээ, бусад тоон мэдээлэл, тайлбар зэрэг нь зөвхөн тухайн мэдээллийг бэлтгэх үеийн байдлыг илтгэх бөгөөд өөрчлөгдөж, хувьсаж болно /Стандарт инвестмент ҮЦК өөрчлөлтийг мэдэгдэх албагүй/. Хөрөнгө оруулагч эрсдлийг өөрөө хариуцна.

Энэхүү тойм мэдээний бүх мэдээллийг зөвхөн мэдээлэл өгөх зорилгоор бэлдсэн бөгөөд найдвартай, сайн санааны үүднээс гаргасан гэж үзсэн эх сурвалжаас авч боловсруулсан хэдий ч мэдээлэл тус бүрийг нэг бүрчлэн хянаж шалгаагүй болно. Тиймээс Стандарт инвестмент ҮЦК нь эдгээр мэдээллийн үнэн зөв, бодит бөгөөд бүрэн бүтэн байдалд баталгаа гаргахгүй бөгөөд мэдээллийг дамжуулахаас үүссэн аливаа алдааг хариуцахгүй. Түүнчлэн, энэхүү тайланг ашигласнаас учирсан аливаа хохиролд Стандарт инвестмент ҮЦК ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

©2020 *Стандарт инвестмент ҮЦК*